

Golomt Capital®

Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.04.24

Олон улсын
хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Онцлох индексүүдийн өөрчлөлт


Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

АНУ-ын индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dow Jones	\$33,811.40	\$34,411.69	-1.74%	\$34,807.46	-2.86%	\$34,043.49	-0.68%
S&P 500	\$4,271.78	\$4,391.69	-2.73%	\$4,511.61	-5.32%	\$4,180.17	2.19%
Nasdaq	\$12,839.29	\$13,332.36	-3.70%	\$14,108.82	-9.00%	\$14,016.81	-8.40%

Европын индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dax	€ 14,142.09	€ 14,153.46	-0.08%	€ 14,473.20	-2.29%	€ 15,320.52	-7.69%
FTSE 100	£7,521.68	£7,561.73	-0.53%	£7,505.41	0.22%	£6,938.20	8.41%

Азийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
CSI 300	¥4,013.25	¥4,125.36	-2.72%	¥4,253.81	-5.66%	¥5,089.24	-21.14%
Hang Seng	HKD 20,638.52	HKD 21,027.76	-1.85%	HKD 21,889.28	-5.71%	HKD 28,755.34	-28.23%
Nikkei 225	JPY 27,105.26	JPY 26,799.71	1.14%	JPY 27,224.11	-0.44%	JPY 29,188.17	-7.14%

Индексийн өөрчлөлт



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

БНХАУ-ын эдийн засгийг 5-аас дээш хувийн өсөлтөд хүргэхийн тулд ковид-19 цар тахлыг хяналтад оруулах хэрэгтэй

БНХАУ-ын ковидын нөхцөл байдал өнгөрсөн жилүүдийнхтэй харьцуулахад дордож байгаа нь эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Өчигдөр тус улсын төв банкнаас эдийн засгийн зорилтод 5.5 хувийн өсөлтөд хүрэхийн тулд макро эдийн засгийн оновчтой бодлого баримтлах нь чухал байна гэж мэдэгдсэн.

Тус улсын нэгдүгээр улирлын дотоодын нийт бүтээгдэхүүний үзүүлэлт өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 4.8 хувиар өссөн.

Шанхай хот нь тус улсын хамгийн их хүн амтай, эдийн засгийн төвд тооцогддог. Гэтэл ковидын нөхцөл байдлаас болж оршин суугчид нь хөл хорионд орж, хоол хүнс, эмнэлгийн тусламж авахад бэрхшээлтэй болж, цалин хөлсөө алдаж, ажилдаа буцаж орж чадахгүй байгаа. Томоохон үйлдвэрүүдийн үйл ажиллагааг зогсоосон нь зөвхөн БНХАУ-ын эдийн засаг гэлтгүй, мөн бусад улс орнуудад сөргөөр нөлөөлж байна.

Тиймээс Бээжин хот дотоодын эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, тус улсын аж үйлдвэрийн нийлүүлэлтийг тогтворжуулж, зах зээлийн хүлээлтийг зохицуулах шаардлагатай байна гэж мэдэгдлээ.

Энэ долоо хоногт хүлээгдэж буй үзүүлэлтүүд

1. Технологийн томоохон компаниуд тайлангаа тавина

Энэ 7 хоногт зах зээлийн үнэлгээгээр тэргүүлдэг АНУ-ын томоохон технологийн компаниуд нэгдүгээр улирлын тайлангаа тавина. Үүнд Apple (NASDAQ:AAPL), Microsoft (NASDAQ:MSFT), Amazon (NASDAQ:AMZN), Google (NASDAQ:GOOGL) компаниуд багтаж байна.

Эдгээр компаниудын хувьцааны ханш энэ жил бүгд уналттай байгаа бөгөөд Apple 9 хувиар, Amazon 13 хувиар, Alphabet 17 хувиар, Microsoft 18 хувиар унасан.

Netflix өнгөрсөн долоо хоногт тайлангаа танилцуулж, 200,000 хэрэглэгчээ алдсанаа мэдэгдсэн даруйд хувьцааны ханш нь эрс унасан.

Мөн Facebook (NASDAQ:FB), Visa (NYSE:V), Mastercard (NYSE:MA), Chevron (NYSE:CVX), Exxon Mobil (NYSE:XOM), Coca-Cola (NYSE:KO), PepsiCo (NASDAQ:PEP) зэрэг компаниуд тайлангаа тавина.

Энэ мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

2. АНУ-ын эдийн засгийн мэдээлэл

Пүрэв гарагт зарлагдах АНУ-ын эдийн засгийн өсөлт, инфляцийн талаарх мэдээлэл энэ долоо хоногт олны анхаарлын төвд байх болно.

Холбооны Нөөцийн Сангаас инфляцийн өсөлтийг зогсоохын тулд эрчимтэй ажиллаж байгаа ч эдийн засагт хэзээ нөлөө үзүүлэх нь тодорхойгүй байна.

Өнгөрсөн долоо хоногт Холбооны Нөөцийн Сангийн дарга Жером Пауэлл Төв банк 5 сарын 3-4-нд хуралдаж, бодлогын хүүгийн хэмжээг хагас нэгжээр нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцэнэ гэж мэдэгдсэн. Энэ нь инфляцийг хяналтад оруулах арга хэмжээнүүдийн нэг юм.

3. Хөрөнгийн зах зээлийн хэлбэлзэл

АНУ-ын голлох индексүүд болох S&P500, Dow Jones Industrial Average, Nasdaq гурван долоо хоног дараалан унасан.

Баасан гарагт Dow индекс 2.82 хувиар унасан нь 2020 оны 10 сараас хойшхи нэг өдрийн доторх хамгийн том уналт байв. Инфляцийн нөхцөл байдал болон компаниудын санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй холбоотойгоор арилжааны хэт их хэлбэлзэл сүүлийн үед түгээмэл болж байна.

Wall Street-ийн айдас хэмжигч гэгддэг CBOE хэлбэлзлийн индекс баасан гарагт өсөж, гуравдугаар сарын дунд үеэс хойшхи хамгийн дээд түвшиндээ хүрчээ.

4. Евро бүсийн тоон мэдээлэл

Евро бүсийн нэгдүгээр улирлын дотоодын нийт бүтээгдэхүүний мэдээллийг баасан гарагт нийтлэх бөгөөд 4 сарын хэрэглээний үнийн инфляци 7.4% буюу Европын Төв банкны зорилтот 2%-иас бараг дөрөв дахин өндөр байх төлөвтэй байна.

Өнгөрсөн долоо хоногт Европын төв банкнаас инфляцийн өсөлттэй тэмцэхийн тулд банк бонд худалдан авах төлөвлөгөөгөө гуравдугаар улирлын эхээр зогсоож, оны эцсээс бодлогын хүүгээ өсгөхөөр төлөвлөж байгаагаа мэдэгджээ.

Гэвч Украины дайн нь эрчим хүчний үнийг өсгөж, нийлүүлэлтийн сүлжээнд саад учруулж, өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

5. Европын компаниудын орлогын тайлан

Энэ долоо хоногт Unilever PLC (LON:ULVR), Nivea үйлдвэрлэгч Beiersdorf (ETR:BEIG), UBS Group (SIX:UBSG), Deutsche Bank зэрэг 140 гаруй Европын компаниуд санхүүгийн тайлангаа зарлах ба энэ нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байна.

Нэгдүгээр улирлын тайлангууд "сайн" байх төлөвтэй байсан ч Украины хямралаас үүдэлтэй үнийн дарамтаас болж одоогоор тодорхойгүй байдалд байна.



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS					The Most Anticipated Earnings Releases				
for the month beginning					April 18, 2022				
(only showing confirmed release dates)									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
18	Netflix	19	IBM	20	ASML	21	Snap Inc.	22	Verizon
25	Coca-Cola	26	Microsoft	27	Meta	28	Apple	29	EgonMobile
02	onsemi	03	AMD	04	Uber	05	Block	06	DraftKings
09	Upstart	10	SoFi	11	CVS Health	12	Coinbase	13	NYC
16	Consensus	17	Walmart	18	Target	19		20	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS					Most Anticipated Earnings Releases				
for the week beginning					April 25, 2022				
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
Coca-Cola	Whirlpool	UPS	Microsoft	Boeing	Meta	Twitter	Apple	ExxonMobil	
Activision Blizzard	PCB	GE	Alphabet	Spotify	PayPal	Caterpillar	Amazon	Chevron	
Otis	Zions Bancorporation	Pepsico	Visa	Cenovus	Ford	Nokia	Roku	Cogate-Almolive	
Philips	Brown & Brown Insurance	3M	GM	T-Mobile	Qualcomm	Southwest	Intel	Abbvie	
Dorman	Crane	Valero	Enphase	Oshkosh	Pinterest	Mastercard	Robinhood	Bristol Myers Squibb	
Bank of Hawaii	Ameriprise Financial	Raytheon Technologies	Chipotle	Teck	Teladoc Health	McDonald's	United States Steel	AstraZeneca	
Lennox International	Cadence	JetBlue	Texas Instruments	Humana	ServiceNow	Merck	Gilead	Phillips 66	
Bank of Marin	Calix	Waste Management	QuantumScope	Harley-Davidson	Sands Las Vegas Sands Corp.	Peabody Energy	Atlassian	Honeywell	
HBT Financial	Hexcel	D.R. Horton	Skechers	American Tower	Hertz	Lilly	Southwestern Energy	Weyerhaeuser	
Community Bank N.A.	Berkley	ADM	Range Resources	ADP	O'Reilly Auto Parts	KLA	Charter Communications		

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.